



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/30

Ховд

Дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт 1 байршилд нийт 157 метр квадрат газар эзэмших эрхийн дуудлага худалдааг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж явуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, анхны үнийг хавсралтаар баталсугай.


3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын холбогдох баримт бичгүүдийг хуулийн дагуу бүрдүүлэх, бусад бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн
А/30 дугаар захирамжийн хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Газрын байршил	Газар эзэмших зориулалт	Газрын талбайн хэмжээ /м ² /	Дуудлага худалдааны анхны үнэ /төг/
1	Жаргалант сум Жаргалан баг Торго төвийн хойд талд байрлах	Худалдаа, үйлчилгээ	157	847 800